

Ц.Бавуудоржийн яруу найраг дахь архетип буюу
аман зохиолын уламжлал

Батмөнхийн МӨНХ-ЭРДЭНЭ*

Монгол Улс, Улаанбаатар хот, Шинжлэх Ухааны Академи,
Хэл зохиолын хүрээлэн, Утга зохиол судлалын салбар

Received: 31 May 2025 / **Accepted:** 15 October 2025 / **Published:** 30 December 2025

Хураангуй: Монгол үндэстний сэтгэлгээний уламжлал, үнэт зүйлс, утга соёлын илэрхийлэл болж байдаг нэгээхэн хэсэг нь домог зүй, домгийн сэтгэлгээ билээ. Ц.Бавуудоржийн яруу найрагт дорно дахин тэр дундаа монголчуудын домог зүй, домгийн сэтгэлгээ, түүгээр илэрсэн бэлгэдэх үзэлтэй нягт холбогдсон байдаг. Өөрөөр хэлбэл, түүний бүтээлд үндэстний сэтгэлгээ, соёлын бүтэц дэх эх дүр, уг гарвал ухамсаргүйгээр уламжлагдсан байна. Тодруулбал, түүний яруу найрагт тэнгэрийг шүтэх үзэл, гэрлийг шүтэх үзэл, сарны бэлгэдэлт дүр зэргийн дүрслэл, өгүүлэмж “архетип” байдлаар уламжлагдсан байна.

Түлхүүр үгс: Яруу найраг, архетип, тэнгэр, сар, гэрэл

Archetypal Motifs and Folklore Traditions in the Poetry of Ts.Bavuudorj

MUNKH-ERDENE Batmunkh

Department of Literature Studies, Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia

Abstract: In the poetry of Ts.Bavuudorj, archetypal images and origins embedded within the cognitive and cultural structure of the Mongol people are transmitted, often unconsciously. More specifically, his work embodies the archetypal motifs of Mongolian cosmological thought, such as the veneration of the sky, the symbolism of light, and the lunar image. A distinctive characteristic of his poetics is the representation of human life not merely within the confines of individual existence, but in its reciprocal interrelation with the cosmic mandala.

Key words: Poetry, Archetype, Sky, Moon, Light

* © Б.Мөнх-Эрдэнэ 2025, E-mail: munkherdene_b@mas.ac.mn



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

1. Удиртгал

Монгол Улсын Төрийн соёрхолт, Соёлын гавьяат зүтгэлтэн, яруу найрагч Цогдоржийн Бавуудорж нь “Бүтээн анир” (1991), “Гүмүда” (1993), “Салхин зүгээс цэцгийн цагаан цоморлог шүхэрлэнэ” (1993), “Дорно аялгуу” (2001), “Амар амгалангийн яруу найраг” (2000), “Сарны шүлгүүд” (2006), “Монголын их амар амгалан” I боть (2008), “Дорно зүгт өвс болно” II боть (2008), “Хүннү туульс” (2011) найраглал, “Хулан хатан” (2012), “Дотоод сансар” (2014) дууль найраглал, “Нар сар сар нар” (2016), “Уянгын шүлгүүд” (2021), “A very big white elephant” (2007), “When humans become grass” (2008), “Un ojo en la palma de mi mano” зэрэг шүлгийн түүвэр хэвлүүлжээ. Хүүрнэл зохиолын төрлөөр “Шувууг сулла” (2018), “Үзэсгэлэнт сараана” (2022) эсээ, өгүүллэг тууж, “Тарнийн цагаан цэцэг” (2022), “Дилова хутагт” (2023), “Цогт Нароба” (2024) зэрэг түүхэн роман бичжээ. Түүнчлэн “Орчлонг хайрлаарай”, “Ээжтэй орчлон”, “Тэнгэрийн бүсгүй”, “Гүрэн Монгол чинь хүлээнэ”, “Алтан нөхөд”, “Хүний сайхан орчлон” зэрэг түүний шүлэг дуу болж олны талархлыг хүлээсэн байна. 2012 онд “Монголын их амар амгалан”, “Дорно”, “Хүрэл чоно” шүлэг, “Агай”, “Хүннү туульс” найраглалын бүтээлээрээ монголчуудын оюун санаа, сэтгэлгээний гүн гүнзгий байдлыг гаргаж, дорнын ард түмний яруу сэтгэхүйг харуулж чадсанаараа Монгол Улсын Төрийн соёрхол хүртжээ. Тэр бээр *“хүнийг, амьдралыг, ертөнцийг өөрийнхөөрөө бясалгаж, таньж, ухаарч гүн ухааны мөнхийн асуудлыг хөндөн дэлгэж эргээд бодгалийн дотоод ай саваар тайлан гэгээрч ингэхдээ нүүдэлч энгийн ахуйгаас эхлээд сэтгэлгээний өргөн багтаамж бүхий урлахуйн өвөрмөц хэлбэрийг бүтээж уран сайхны сэтгэлгээний нэгэн төлөвшилийг харуулж”* (ЯУТ-II, 2009: 182) буй уран бүтээлч юм.

Түүний яруу найргийн сэдэв нь монгол ахуй, сэтгэлгээ нь дорнын хэв маягтай. Бүтээлийнх нь амт, үнэр, агаар ч дорно зүгийн өнгө аястай. Өөрөө ч *“Дорно зүгт би өвс болж төрнө”* хэмээн шүлэглэсэн нь бий. Наран, саран, огторгуй ертөнц, цагаан гэгээ, манант үдэш гээд хүмүүн болоод юмс үзэгдлийн гэрэл гэгээт талыг сэрж мэдэрч, яруу найрагтаа нээж, юмсын эгэл энгийн сайхныг дуулдаг онцлогтой. Шүлгүүд нь дорно дахины гүн ухааны уламжлалтай, бодол бясалгалын өнгө аяс бүхий, бадаг мөр, үг аялгууг тэгш тэнцүүлж зохист аялгууны урлахын хэм хэмжээ барьж туурвисан байдаг. Түүний шүлгүүдэд ажиглагддаг өөр нэг онцлог бол уянгын мэдрэмж, түүнээс эхтэй ер бусын илэрхийлэл, хөг аялгууны зохилдоот чанар юм. Энэ нь шүлэгт эрхэмсэг зөөлөн өнгө аясыг бүрдүүлэхээс гадна утгын гүнзгийрэлт хийх, санааны тэлэлтийг хангах өргөн боломж олгохоос гадна шүлгийн философийг хэтэрхий ил тод, эсвэл хэт гүн ухаанчлан тогтоосон нэгэн хэвийн гэмээр хэллэг дүрслэлээс зайлсхийх, яруу дуун болгох боломж олгодог онцлогтой. *“Оюун ухааны аялал нь шүлэг яруу найраг болон гэрэлтэн хоцордог сэтгэхүйн алслалаар юмс үзэгдлийг хөвөрдөн учигласан, эх орон, нутаг усаа гэсэн элгэн халуун сэтгэлээр түүхэн хатдын тухай нэхэж өгүүлсэн хийгээд сарны орон зайн дүрслэлт буулгавар тэргүүтэн нь шинэ яруу найргийн, тэр тусмаа дорнын, монголын яруу найргийн шинэ төрх, ур хандал, чадал чансааг илтгэдэг. Жүнзтэй дарсны уйтгарлалыг тандан мэдэрсэн дүрслэлийн чанадын сэтгэмж, ланз үүл гэх мэтийн давтамжит дүрслэл бүхий хэмнэл айзмын жигдрэл, үгийн сонголт чөлөөтэй нь дорно гэх намба аястай, утгын өргөн цараа хүрээтэй дүрслэгддэг онцлогтой юм. Өөрөөр хэлэхэд утгыг голчилж, ураар тэгшилдэг билгүүн их сэрэл, эгээрэл түүний найраг шүлэгт гэрэлтдэг. Гэгээн сэрэл, торгон мэдрэмжээ анирдсан зөн сэрэхүйн дуулал гэгэлзэж хэмнэл айзам бүхий төсөөт үгээр сүүл толгойг ижилсүүлэн авиа дуурайлдаг нь түүний яруу найргийн далд уянга, дотоод тэмтчилд онцгой байртай юм. Хөг яруу, хөгжимлөг хайрцаглал, уянгын тэнцүүлэлт нь сонгодог монгол бичгийн яруу найргийн үр хөврөлийг баттай хадгалсанд оршино. Ийнхүү хэмнэл зохис, хээнцэр уран шүлэглэл, задгай хүүрнэл айзмын таслалт зэрэг нь утгын гүнд шүтэгдсэнээрээ уянгыг бадрааж, ухаарлыг эрчимжүүлжээ. Иймийн учир үгийн мэдрэмж, утгын зохицлоор яруусч, уянгын давталт, ухааны бясалгал, урын гүнзгийрэл нь нэвт сацарнам”* (Цэвээндорж, 2009: 276).

2. Судалгааны арга зүй

Бид судалгааны арга зүйн хувьд цуглуулсан эх хэрэглэгдэхүүнээ задлан шинжлэх, тайлан тайлбарлах аргыг хослуулан хэрэглэсэн болно. Бидний олж үзсэнээр түүний туурвил зүйн сэтгэлгээний гүнзгийрэл далайц, уран сайхны шинэчлэл хийсэн арга барил,

бодрол бясалгал, гүн ухааных нь үзэл баримтлалын талаар уран зохиол судлаач, шүүмжлэгч Ч.Билигсайхан “Монгол найргийн өргөө эзэнгүйдэхгүй нь ээ” (2002), Д.Галбаатар “Дорнын шүлгүүдийг уншаад...” (2006), А.Мөнх-Оргил “Амар амгалангаас гэгээрэлд хүрсэн зам” (2007), Х.Сүглэгмаа “Цогт Очирваанийн их шүлэгч Цогдоржийн Бавуудорж” (2008), Д.Цэвээндорж “Цаг хугацааны гэрэлт ертөнцийг анирдсан Цогдоржийн Бавуудоржийн сэтгэлийн аяз” (2008), С.Дулам “Ц.Бавуудоржийн “Монголын их амар амгалан”-гаас “Рах mongolica” хүртэл” (2011), Я.Ганбаатар “Хүннү туульс” хүчирхэг дуурьсаж байна” (2011), Г.Батсуурь “Амар амгалангийн дайд” (2012), Л.Мөнхтөр “Сарны шүлэгч буюу Цогдоржийн Бавуудорж” (2012), Х.Чойдогжамц “Ц.Бавуудоржийн туурвил зүйн “хялбарчлал” ба “хоёр төвт” шүлгүүд” (2013) зэрэг шүүмж бичсэн нь бий. “Тэртээ 90-ээд онд “Намрын борооноор цувгүй алхахдаа, Навчнаас дутуугүй гуниг тээдэг дээ...” хэмээн хотлыг дуулуулан гарч ирсэн яруу найрагч Ц.Бавуудорж эдүгээ монголын яруу найргийн их дайдын дорно этгээдэд өөрийн бууцыг дугуйлсан буй” (Батсуурь, 2012). Энэ мэтчилэн түүний уран бүтээлийн онцлог, туурвил зүйн уран чадвар, бүтээлүүдийнх нь үнэ цэнийг эрдэмтэн судлаачид судалж өөр өөрсдийн үнэлэлт дүгнэлтээ өгсөн байдаг. Тиймээс бид энэ талаар давтан өгүүлэлгүй түүний зохиолуудад буй архетип буюу аман зохиолын уламжлалын талаар өгүүлэхийг хүслээ.

3. Аналитик сэтгэл зүйн онол, түүний ойлголтууд

Аман ба бичгийн уран зохиолын харилцаа холбоо, уламжлал шинэчлэлийн залгамж чанарын асуудал уран зохиолын туурвил зүйд нэгэн чухал судлагдахуун болсоор ирсэн бөгөөд “урлаг утга зохиолын хувьд хэрвээ үнэхээр уран сайхантай сайн зохиол бичье, бүтээе гэвэл урьд үеийн түүх, туршилага, түүний аль сайн дээр түшиглэх нь зүй ёсны хэрэг” (Байгалсайхан, 1995:15) юм. Эл уламжлал, шинэчлэлийн залгамж харилцааг судлахад аналитик сэтгэл зүй онол, түүний ойлголтууд тус болно гэж бид үзэж байна.

Швейцарын сэтгэл зүйч, эмч Карл Густав Юнг (Carl G.Jung)-ын үндэслэсэн Аналитик сэтгэл зүйд “хамтын ухамсаргүй” (collective unconscious), “архетип” (archetypes) зэрэг тулгуур ойлголтуудыг авч үздэг. “К.Г.Юнг психи (сэтгэл) гэдэг ойлголтыг авч үзсэн бөгөөд тэр нь ухамсар, хувийн ухамсаргүй, нийтийн ухамсаргүй гэсэн бүрдлүүдтэй. Ухамсар нь эгэд хүртэгдсэн бүхнийг хүлээн авч ойлгон ухаарах байдал, эгэ нь ухамсрын төвд байрлах боловч ухамсаргүйтэй холбоогүй, дангаараа хувь хүнийг бүрдүүлж чадахгүй гэж үзсэн бол хувийн ухамсар гэдэг нь хүний төрсөн цагаас эхлэн хуримтлуулсан сэтгэцийн туршилага буюу мартагдсан хийгээд эс мартагдсан бүхий л дурсамж, мэдээллүүдийн цогц аж. Харин нийтийн ухамсаргүй нь хувийн ухамсаргүйгээс цааших зүйл агаад нийт хүн төрөлхтний хөгжлийнхөө явцад хуримтлуулсан бүхэл бүтэн цогц мэдээллийн сан” (УЗШ, 2021: 675) аж.

Юнг дэлхийн олон үндэстэн, угсаатны үлгэр домог болон хуучны соёл, бэлгэ тэмдгүүдийг судалж үзээд тэдгээрт ижил төстэй шинж чанар, дүр, зан үйл, бэлгэдэл буйг олж харсан байна. Өөр өөр соёлуудад буй бэлэг тэмдгүүд нь ямар нэг байдлаар хоорондоо холбоотой, адил төстэй нийтлэг шинжтэй байсан тул тэрхүү хүн төрөлхтний сэтгэлгээний нийтлэг хэр нь далд нууцлаг ертөнцийг хамтын ухамсаргүй гэж нэрлэжээ. Хамтын ухамсаргүй нь хүний сэтгэл зүйн далд, нууцлаг гүн ертөнц тул шууд мэдэрч чаддаггүй, харин архетипүүдийн дохио, өгөгдлүүдээр мэдрэгдэж хүний үйл ажиллагаанд нөлөөлж байдаг аж. Өөрөөр хэлбэл, нийтийн ухамсаргүй нь хүн төрөлхтний сэтгэл зүйн маш нууцлаг гүнд орших ба хүмүүст янз бүрийн дохио тэмдгүүдээр илэрч гарч ирдэг гэж үзжээ. Тэрхүү дохио, бэлгэдлүүдийг К.Г.Юнг “архетип” хэмээн нэрлэжээ. “Домог үлгэрүүд нь энгийн нэг зохиол төдий зүйлс биш гэдэг дээр Юнг санал нэг байжээ. Домог үлгэр бүрийн цаана нууцалж, далдалж, бас хойч үедээ үлдэхийн тулд кодолсон мэдээллүүд дүүрэн байх ёстой гэж үзсэн юм...” (Энхтүшиг, 2019:153). “К.Г.Юнгийн тодорхойлсноор: “...Ухамсарт бус зүйл бол өнгөрсөн түүхийг хадгалагч сав төдийгүй, ирээдүйд буй болох сэтгэл санааны нөхцөл байдал болон үзэл санааны үр хөврөлүүдийг агуулдаг” ажээ. Товчхоноор хэлбэл сэтгэхүйн сэлгэц, нөхөн үйлдвэрлэл, сэтгэхүйн хувьсал (thought evolution) гэж хэлж болно” (Бямбаням, 2012).

Архетипыг хамгийн товчоор тодорхойлбол эртний сэтгэхүй, өвөг дүр гэсэн утга гарна. Энэ тухай Юнг “Архетип гэдэг бол нарийн эдүүд нь ялимгүй хэлбэлзэх хэр нь суурь бүдүүвч

зураглалыг хэвээр нь хадгалж чадсан төсөөллийг, сэдлийн иймэрхүү төсөөллийг бүрдүүлэх хандлагыг хэлдэг. Мөн чанартаа архетипүүд бол шувуу үүрээ барих гэж, шоргоолж овоо сууцаа босгох гэж зөнгөөрөө зүтгэдэг шиг зөнгөөр залагддаг чиглэлт хандлага (тренд) юм. Энд архетип зөн хоёрын ялгааг хэлэх хэрэг гарлаа. Бидний зөн гээд буй зүйл бол мэдрэлийн эрхтнээр хүртэж болох физиологийн үйл юм. Гэтэл зөн ийм мөртөө, хий мөрөөдөлд өөрийгөө илэрхийлж, ялангуяа зөвхөн бэлгэдэлт дүрүүдэд өөрийнхөө оришиж буйг илэрхийлэх нь элбэг байдаг. Энэ илрэлүүдийг л архетип гэж би хэлдэг” (Юнг, 2011: 203) гэжээ.

“Архетип нь үндэстний сэтгэлгээ, соёлын бүтэц дэх эх дүр, уг гарвал ухамсаргүйгээр дараа дараагийн үед мөнхөд улбаран уламжилдаг шинжтэй. Харин суурь бүдүүвч зураглалыг хэвээр хадгалж чадсан хэр нь ялимгүй хэлбэлздэг байна. “Гүн гүнзгий байдлаар удамшиж ирсэн хамтын ухамсаргүй аугаа их хүчний түүх, дүрслэл санааг олон талын аргаар ухамсарт байдлаар дамжуулан илэрхийлдэг. Юнг тэрхүү хамтын ухамсаргүйн үндсэн дүрсийг архетип гэж нэрлээд, хүн төрөлхтний хүсэл, туулж өнгөрүүлсэн амьдралынх нь үндсэн тусгал болох шаашин, домог хоосон мөрөөдөл, үлгэр, зөгнөл, зүүд зэрэг яагаад олон дахин илрээд байна вэ гэдгийг нарийвчлан судалсан юм. Архетипын дүрслэлд баатар, хүүхэд, чөтгөр, хөгишин хүн, газар дэлхий гэх мэт зүйлс үзэгддэг” (Энхтүшиг, 2019:154) аж.

“Янз бүрийн архетип бий. Тухайлбал, мангас, баатар эр, цэцэн өвгөн, өнчин хүү гэх мэт. Өөрөөр хэлбэл аль ч үндэстний эртний дүрслэх сэтгэлгээнд сөрөг талын дүрийг ямар нэгэн мангасаар төлөөлүүлэн үзүүлдэг бол эерэг дүр нь баатар эр байдаг” (Батсуурь, 2018: 74) ажээ. Баларлаг үеийн хүмүүсийн сэтгэлгээний илэрцүүд нь архетипүүдээр дамжин бидэнд ирдэг бөгөөд сэтгэцийн өвчтөнүүдийн яриа, төсөөлөлд илэрдэг хэв шинжүүд нь эрт үеийн хүмүүсийн сэтгэлгээний зарим элементүүдийг ямар нэгэн хэмжээгээр агуулж байдгийг тогтоосон байна. Тэдгээр нь үлгэр домгуудад ч мөн давтагдах ба жишээлбэл, мангас, баатар, үлэмж биетнүүд, дагинас, чөтгөр шулам мэтийн сүүдрийн төлөөллүүд... гээд олон архетипүүд үндэстэн бүрийн үлгэр домгуудад давтагддаг байна.

“Монголын эрт ба эдүгээгийн уран зохиолын түүх бүхэлдээ уламжлал шинэчлэлийн түүх бөгөөд монголын бичгийн сонгодог уран зохиол, орчин үеийн уран зохиолын шилдэг хэмээн үнэлэгдсэн зохиолууд аман зохиолын туурвил дээр суурилан уламжилсан шинэчлэл. Тодруулбал, тухайн зохиолын шилдэг гэж үнэлэгдэх үнэлэмж нь нэг талаар аман зохиолын тодорхой төрөл зүйлийг шинэчлэн боловсруулж, шингээн хөгжүүлсэнтэй холбоотой” (Ууганбаатар, 2018: 245).

Монгол үндэстний сэтгэлгээний уламжлал, үнэт зүйлс, утга соёлын илэрхийлэл болж байдаг нэгээхэн хэсэг нь домог зүй, домгийн сэтгэлгээ билээ. Ц.Бавуудоржийн яруу найрагт дорно дахин тэр дундаа монголчуудын домог зүй, домгийн сэтгэлгээ, түүгээр илэрсэн бэлгэдэх үзэлтэй нягт холбогдсон байдаг. Өөрөөр хэлбэл, түүний бүтээлд үндэстний сэтгэлгээ, соёлын бүтэц дэх эх дүр, уг гарвал ухамсаргүйгээр уламжлагдсан байна. Тодруулбал, түүний яруу найрагт тэнгэрийг шүтэх үзэл, гэрлийг шүтэх үзэл, сарны бэлгэдэлт дүр зэргийн дүрслэл өгүүлэмж “архетип” байдлаар уламжлагдсан байна.

4. Ц.Бавуудоржийн яруу найраг дахь архетипүүд

4.1. Ц.Бавуудоржийн яруу найраг дахь сав шимийн дуулал

“Сав шимийн мандал дунд хүний ертөнц оршин тогтоно. Гэхдээ сав шим мандал нь хүний орчлонг багтаах орон зай төдий бус. Харин сав шим мандалтай хүн төрөлхтөн харилцан шүтэлцээ дунд оршино. Төв Азийн өндөрлөгт аж төрж байсан Монгол удам угсааны хүн зон, хад чулуу, өвс ургамал, араатан жигүүртний хүрээлэл дунд амьдарч нэгийг угтан нөгөөг үдэн он жилийг улираасан нь мэдээж. Тэнгэр газрын хооронд, төрөх, нөхчихийн тавилан дунд хүн олон, сав шим мандлын хишиг буян, гамшиг нүглийн аль алиныг өөрийн төсөөлөл, ойлголтоор сэрж мэдэрсээр иржээ” (Цэдэв, 2002: 28). Тиймээс ч монгол аман зохиолд хүн-байгаль хоёр эх-хүүхэд мэт хүйн холбоотой гэдэг ойлголтыг агуулсан байдаг. Эл ойлголт Ц.Бавуудоржийн бүтээлд ч уламжлагдсан байна. Түүний яруу найргийн нэгэн онцлог нь хүний амьдралыг дан ганц оршихуйн хувийн хүрээнээс бус, харин сав шимийн мандалтай харилцан уялдаатайгаар дүрслэхэд оршдог. Зарим шүлэг нь зөвхөн уянгын зурвас мэдрэмж бус, харин дэлхий-байгаль-

хүний хүйн холбоог туульслаг аялгуугаар өгүүлсэн “дуулал” шинжтэй байна. Тухайлбал, “...*Агь сүмэн өвсний дураар гуниглах...*”, “...*одны нь гэгээнд үзэгдэх өвс мэт...*”, “...*Ует шаргал өвс үзүүр алдан бөхөлзөж Хүмүүнийг долгиулсаар байхад...*” гэх зэргээр хүний сэтгэл, оршихуйг өвс ургамалтай зүйрлэж, хүний хувь заяа, байгалийн амьдрал хоёр ижилсэж буйг харуулжээ. “Намрын өвсөн дунд” шүлэгт:

“Энгүүхэн хөх өвсөн дунд

Эрхэмсэг оршихуйг анзаарч суунам

Яг энэ эгэл өвс шиг

Яруу сайхан бясалгахыг хүснэм” хэмээн “өвс” гэх жирийн нэгэн байгалийн дүрслэлийг хүний дотоод ухаарал, бясалгалтай холбожээ. Энд “*энгүүн хөх өвс*” нь хүний амьдралын даруу, эгэл боловч эрхэм чанарыг бэлгэдэхийн зэрэгцээ байгаль дундах хүний амьдралын үнэ цэн, оршихуйг анзаарах эргэцүүллийн эх сурвалж болон хувирч байна. Энэ мэтээр түүний яруу найрагт сав шимийг дуулсан шүлгүүд зөвхөн уул ус, тэнгэр газрын уялдаа төдий бус, харин хүний дотоод ертөнц, амьдралын жам, хагацал учрал, хайрын ухааралтай холбогддог. “Алга урвахын шүлэг”, “Сарны туяагаар бичсэн тэмдэглэл”, “Туниг” зэрэг бүтээлд байгаль-сав ертөнцийн дүрслэл хүний оршихуйн гуниг, сэтгэлийн дотоод эргэцүүлэлтэй нийлж, нэгэн бүхэллэг “дуулал” болж хувирдаг. Энэ талаар ч судлаач Г.Батсуурь тэмдэглэсэн байна. Тодруулбал, “*Түүний яруу найрагт орчлон ертөнц, байгаль дэлхийн өнгө дүрс, байр байдал гүнзгий туссан байх бөлгөө. Тэдгээрийг нь “Нэг их том цагаан заан”, “Цав цагаан цастын орноо орхиод”, “Манан будан”, “Шар нарны дууль”, “Бурхадын дууль”, “Гэтлэхгүйн цэнхэр хязгаар”, “Уянга”, “Нэгэн цагт”, “Очирваань уулын цагаан үүл”, “Өнөд тунгалаг наран дор”, “Монголын их амар амгалан”, “Монголын их хувь тавилан”, Дөрвөн улирал” шүлгүүд болон “Очирваань” найраглал зэрэг дорнын сэтгэлгээгээр үзвээс сав ертөнцийн учир зохирлын тухай шүлэг дуулууд юм*” (Батсуурь, 2012). “Очирваань уулын цагаан үүл” шүлэгт:

“Очирваань уулын цагаан үүл

Орчлонд намайг дагаж нүүдэг

Мөнхийн ногоон арц нь хүртэл

Мөр замыг минь хучиж ургадаг

Очирваань уулын цагаан салхи

Орчлонд намайг дагаж салхилдаг

Алтан увдист хурмаст нь хүртэл

Амгалан тавиланг минь адисалж байдаг...” хэмээн шүлэглэсэн бий. “Энд дурдагдаж буй Очирваань уул гэдэг бол Отгонтэнгэр уул бөгөөд уг уулын эзэн савдагтай холбон ийн хэлсэн аж. Ертөнцийн гуравт Тагт ургасан арц ногоон гэж байдаг ба ер нь ногоон өнгө бол өвс ногоон гэдгээс үүсэлтэй ургаж төлжихийн бэлгэдэлт санаа учир ийн дүрслэгджээ. Мөн ийнхүү сав ертөнцийг шүлэглэхийн зэрэгцээгээр хүний амьдралын жам ёс, эргэж буцахын учир санах эгээрэхийн шалтаг шалтгаан хийгээд хайрлах хайрлуулахын ухаарал дүрслэгдэх. Тэдгээрийг нь “Алга урвахын шүлэг”, “Харсаар байтал”, “Туниг”, “Гөлгөнд зориулсан шүлэг”, “Харсаар байтал”, “Сарны туяагаар бичсэн тэмдэглэл”, “Санаж явсан чамтай”, “Өвлийн аяз”, “Тунгалагийн тухай шүлэг”, “Дорнын хөх тэнгэр”, “Дорно”, “Цастын аяз”, “Шаргал аяз”, “Тэнгэрийн бүсгүй” зэрэг мөн л олон бүтээлүүдээс нь үзэж болох ба эдгээр нь мөнөөхөн дорнын сэтгэлгээгээр үзвэл шим ертөнцийн учир зохирлын тухай шүлэг дуулууд гэлтэй. Ц. Бавуудоржийн энэхүү дорно дахины мэт уламжлалыг нарийн анзаарвал ардын аман зохиолын ба сонгодог бичгийн зохиолын түүний дотор туульслаг өнгө аяс нэлээд тодорхой туссан байх нь мэдэгдэнэ (Батсуурь, 2012). Түүнчлэн “Нэг том цагаан заан” шүлэг нь бидний өгүүлэн буй сав шим ертөнцийн үүслийн тухай домгийн өгүүлэмжтэй холбогддог. Тодруулбал,

“Нэг их том цагаан заан

Дэлхий дээгүүр яваад өнгөрлөө

Хүчирхэг тэнгис далайн

Дөлгөөн чанарыг дагуулаад явчихлаа

Хөрст дайдын

Намуун байдлыг суйлаад явчихлаа

Дорнын нууцхан инээмсэглэлийг арчаад буцчихлаа

Дотоод анир гүмийг нь

Эвдээд буцчихлаа

Навчин дээрээс шүүдрийг нь

Сэгсрээд явчихлаа...” гэх өгүүлэмж гардаг. Энэ нь дорно дахины, тэр дундаа энэтхэгийн домог үлгэрт “дэлхий ертөнц аварга том заан дээр тогтдог хэмээх”, “космогоник”¹ өгүүлэмжтэй холбогдоно. Төв Азийн аман домогт дэлхий аварга загас, төмөр үхэр, эсвэл заан зэрэг аварга амьтдын нуруун дээр тогтдог тухай өгүүлэмж түгээмэл бий. Тэдгээрт хэрэв заан толгойгоо сэгсэрвэл газар хөдлөлт болдог гэж тайлбарладаг. Энэ нь байгалийн гамшгийг тайлбарлах эртний хүмүүсийн гэнэн сэтгэлгээ юм. Энэхүү гэнэн сэтгэлгээг найрагч бүтээлчээр ашиглан энэхүү шүлгийг бичжээ.

4.2. Ц.Бавуудоржийн яруу найраг дахь тэнгэрийн дүрслэлүүд

“Яруу найргийн нандин авьяас мэдрэмжийг эртэй сайндаа би өөртөө бий болгоогүй. Монголын хөх тэнгэр, нар сарны надад өгсөн бэлэг. Тийм болохоор энэ чавхдасыг хөглөн дуугаргасаар байх “зарлиг” зүрхний минь гүнээс ундардаг гэх үү дээ”

(Ц.Бавуудорж хэвлэлд өгсөн ярилцлагаас)

“Ертөнцийн хоёр хэмжээст хавтгай загвар дээр босоо хэмжээс нэмж, доод тивийг буй болгосноос гадна дээд тив, тэнгэрийн орныг буй болгожээ. Тийм болохлоор дээр хөхрөгч тэнгэр, наран саран, одон мичид зэрэг бүх эрхэс цөм домгийн дүрүүд болон хувирдаг бөгөөд эртний яруу найрагт дүрсэлсэн ёсоор “алтан наран гэрэлт алман саран туяат Эрхэт Мөнх тэнгэр” болдог байна. Монгол домогт чухам энэ үеэс эхлэн тэнгэрийн үүтгэлийг нэн эрхэмлэх байдалтай болжээ... Хэдийгээр байгалийн үзэгдлийнх нь хувьд тэнгэрийг хэвээр шүтэх ёсноос эхэлсэн боловч дараа нь тэнгэрийг өөрийг нь тэнгэр болгож, сүүлдээ тэнгэр, түүний эзэн хоёрыг ялгах мэтчилэнгээр хэд хэдэн үе шатыг дамжсан байна” (Дулам, 1989: 65). Ийнхүү монгол утга соёлд тэнгэрээс гаралтай гэх “тэнгэрийн хөвгүүн”, “тэнгэрийн охин”, “тэнгэрийн дагина”, “тэнгэрийн зүүдний хүү”, “тэнгэрийн гүүний унага”, “тэнгэрийн цагаан чоно”, “тэнгэрийн тэгш таван хүсэл”, “номт тэнгэрийн жаргал” гэх домгийн сэтгэлгээ бий болжээ. Тодруулбал, “Монголын нууц товчоо”-ны эхлэлд:

“Чингис хааны узуур.

Дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно ажгуу. Гэргий инү Хоо марал ажээ” (МНТ, 2011: 8)” гэсэн тэнгэр язгуурт гэсэн домоглол бий. Эл домгийн сэтгэлгээ аман болон бичгийн зохиолын нэгэн хэвшилт дүрслэл [formula] болж уламжлагдсаар ирсний хамгийн тод жишээ нь Ш.Сүрэнжав “Би тэнгэрийн хүү” бүтээл юм.

Ц.Бавуудоржийн яруу найрагт байнга анзаарагддаг нэгэн давтамжит дүрслэл бол түүний тэнгэрийг шүтэх үзэл юм. Шүтэх гэхээр магадгүй явцуу ч байж болох юм. Ерөөс өөрийгөө тэнгэрийн харьяат гэж “одны нь гэгээнд үзэгдэх өвс мэт” үзэх, эсвэл тэнгэрийг өөрийн оюун санааны харьяат болгож “тэнгэрийн хишгийг цалгиагаагүй” гэх мэтийн дүрслэл нь түүний яруу найргийн амин сүнс нь болдог. Чингэхдээ орчлонд хүмүүний төрлийг олох, төрөх үхэх, ирэх, буцах, жаргах, зовох бүгдийг тэнгэрийн эрхшээлээр гэж түүн лугаа дүйж сэтгэн бичдэг. Тодруулбал,

“...Тэнгэр миний гүн ухаан

Тэндээс бурхадны шаргал амьсгал сонсогддог...” гэх буюу:

“Анирхан хөх тэнгэр, газар усны тарнич

Ариухан намар цаг бол бурхны сэтгэл мөн өө” гэх зэргээр бичдэг. Тэр бээр “тэнгэр”-ийг зөвхөн байгалийн үзэгдэл бус, оюун санааны эх сурвалж, хүмүүний амьдралын оршихуйн үндэс болгон яруу найрагтаа дүрсэлдэг онцлогтой. Өөрөөр хэлбэл, тэр бээр тэнгэрийг “сүнслэг оршихуй”, “гүн ухааны эх сурвалж” болгон ойлгох хандлагатай байна. Энэ нь түүний шүлэгт уянгын мэдрэмжээс илүүтэйгээр туульслаг аялгуу, домог-философийн өнгө аяс шингэсэн “дуулал” шинжийг бий болгодог. Тухайлбал, “Сэтгэл” шүлэгт:

“Өндөр тэнгэрийн нэгээхэн мөчир дээр

¹ Эртний грекийн “Kosmos”-ертөнц, дэг журам, + “gonos” (төрөлт, гарал үүсэл) гэсэн үгээс гаралтай нэр томъёо. Дэлхий ертөнц, орчлонгийн үүсэл, гарал хөгжлийн тухай өгүүлсэн үзэл, домог, уран сайхны дүрслэл. Орчлон ертөнц хэрхэн үүссэн тухай тайлбарласан домог, уран зохиолын төрлийг ийн нэрлэнэ.

Үл үзэгдэх шувуу шиг суунам
 Үзэсгэлэнт мэдрэмжийнхээ өдөөр
 Үдэш бүхний саран дээр гэгээхэн сэтгэл урланам
 Хуйлран догширох орчлонгоос сүвд шүүрдэх нэгэнд
 Уурга болог
 Хуудас бүхэнд нь билиг нуугдсан судрын
 Гээгдсэн үсгийг орлох гэрэл болог
 Орь ганц тэнүүлчид хоног төөрүүлэх урц болог
 Огторгуйг таньсан даяанчид эрдэнийн олбог болог
 Ангаж яваа нэгэнд балга сүү болог
 Амьдралын модны мөчир дээрх хөхөө болог
 Дотроосоо гэрэлтсэн нэгэнд бодь мод болог
 Дорнын мэлмийнээс тасрах лянхуаг тосох алганы хонхор болог
 Тэнгис байгаад ширгэж одсон их усны

Тэнгэрийн ой санамжид үлдсэн давлагаа нь болог” хэмээн зохиолч өөрийгөө “үл үзэгдэх шувуу” болгон төсөөлж, тэнгэрийн өндөрлөгөөс хүмүүн төрөлхтөнд буян хишиг түгээгчийн дүрд оржээ. Тэндээсээ тэр бээр хүмүүст “уурга”, “гэрэл”, “урц”, “олбог”, “сүү”, “хөхөө”, “бодь мод”, “лянхуаг тосох алга”, “тэнгэрийн ой санамжид үлдсэн давлагаа” зэрэг ариун бэлгэдлүүдийг түгээж буй дүрслэлээр тэнгэрийн хүүгийн байр сууринаас хүмүүний оюун, сэтгэлийг тэтгэж буй өгүүлэмж бүтээсэн байна. Түүнчлэн нэргүй нэгэн шүлэгт нь:

“Усанд буусан дүүрэн цагаан саран дээр
 Утгын хөх амуу тариалах гэж зүдэрсээр
 Уяхан ижийнхээ үнэн хар гээгэнд
 Тэнгэрийн цас унагаж
 Нэгэн цагийг орхив би

Нэгэн цагийг...” хэмээн бичжээ. Шүлэгт “утгын хөх амуу” нь бичиг зохиол, яруу шүлэг гэсэн утгын шинэ нэршил болж байхад “тэнгэрийн цас” хэмээх нь буурал суух, өтлөхүйн ёгт илэрхийлэл болжээ. Энэ мэтээр тэр бээр “тэнгэр”-ийг дүрсэлж бичсэн жишээ олон бий.

4.3. Ц.Бавуудоржийн яруу найраг дахь сарны дүрслэлүүд

“Дээр мөнх тэнгэрийг амьдчилан дүрслэхийн хамтаар тэнгэрийн бүх эрхэс одон гараг цөм домгийн дүрүүд болон хувилдаг. Ийм учраас нар, сарны холбогдолт эртний домгийн дүрүүд нэгэн адил үүсэж хөгжсөн байна. Монгол домог зүйн эх бичгүүдээс ажиглан үзвэл монголчууд эрт дээр цагаас нааш тэнгэрийн үй олон эрхэс гарагийн дотроос “алтан нар”, “алман сар” хоёрыг бүхнээс илүү эрхэмлэн хүндэтгэж байсан байна” (Дулам, 1989: 86). Монголчуудын хувьд алман сарны бэлгэдэл хүндтэй байртай. Сар нь монголчуудын эртний өвөг дээдсийн нэг зүйл шүтээн, “алтан нар”-ны хамтаар мөнх тэнгэрийн оройн чимэг болдог. Алман хэмээх нь дугариг хэлтгий, хавирган сар гэсэн утгатай. Монгол домог зүйн эх бичгүүдээс ажиглан үзвэл монголчууд эрт дээр цагаас нааш тэнгэрийн үй олон эрхэс гарагийн дотроос “Алтан нар”, “Алман сар” хоёрыг бүхнээс илүү эрхэмлэн хүндэтгэж ирсэн байна. “Наран эцэг, саран эх” хэмээдэг нь нарыг арга буюу эр, сарыг билиг буюу эм хэмээн бэлгэдэж ирснийг харуулдаг. Монгол улсын эрх чөлөө тусгаар тогтнолын бэлгэ тэмдэг болсон соёмбо үсгийн дээр бадран ноцож буй гал, мандаж байгаа нар, сарыг дүрсэлсэн нь эрт цагаас монголчууд нар, сарыг гэрэл гэгээ, өөдлөн мандахын бэлгэдэл болгодог байсныг гэрчилнэ. Эл сарны тухай Д.Нацагдорж, Б.Ринчен, Б.Явуухулан, П.Бадарч, О.Дашбалбар, Б.Лхагвасүрэн, А.Эрдэнэ-Очир, Г.Аюурзана, Л.Өлзийтөгс гээд олон яруу найрагч өөр өөрсдийнхөөр дуулан шүлэглэсэн байдаг. “Сар” хэмээх нэгэн сэдвийн дор төрөл бүрийн сэдэл санаатай, өвөрмөц дүрслэлтэй, давтагдашгүй сонин зохиомжтой, шууд ба далд санаа бүхий, олон янз хувилбартай хэдэн зуугаар тоологдох шүлэг найргийг монгол зохиолчид бүтээсэн байдаг. Өөрөөр хэлбэл, монголын уран зохиолд “сар” нь бүхэл бүтэн бэлгэдэлт утгын коридор үүсгэдэг, биеэ даасан шинж бүхий дүрслэл болоод хэвшин тогтсон, хэвшлийн онол (Formulaic theory)-ын үүднээс “Formula” болсон дүрслэл гэж хэлж болно. Энэ тухай өгүүлбэл нуршсан урт зүйл болох тул энэ удаад азная.

Ц.Бавуудоржийн яруу найргийн дүрслэлд ч “сар” нь чухал байр эзэлдэг, давтамж үүсгэсэн дүрслэл юм. Тэр бээр “сар”-ыг олон төрөл, янзаар дүрслэн бичсэн байна. Тухайлбал: *“уйтай сар, шинэ сар, хагалбарт мөнгөн сар, урд оны сар, алгуур сар, төгөлдөр сар, хөх сар, шинэтгэл сар, зоргоор сар, шаргалхан сар, улбар сар, бүлээн сар, ялдам сар, шүүдэрт сар, дүүрэн хөх сар, гэгээн сар, гэрэлт сар, идэрхэн сар”* гэх мэтээр сарыг хүний сэтгэлийн нүдэнд хүртэж болох тэр л өнгөнүүдийг уран сайхны хэлээр тодорхойлж, сарны араншныг хүнчлэн, сарны мөн чанарыг тодруулсан олон дүрслэлийг бичжээ. Тодруулбал:

“Сарны хөлд шаргал өвсний шүүдэр сүүдэхүй

Салхины мэдрэмж алганы хээнд сарнина...” гэх мэтчилэн шүлэглэсэн буй. *“Олонх шүлэгч, яруу найрагчид сарыг тэргэл, хавирган мэлтэлзсэн, хээр хоносон гэхчлэн бодот ахуйг нь тодруулах замаар уран бүтээлдээ дүрсэлсэн байдаг бол Ц.Бавуудорж их л өөрөөр саранд их ойрхон очиж, хүүрнэн ярилцаж, хамтдаа алхаж, уй гуниг, баяр жаргалаа хуваалцаж, хэзээ ч салиггүй анд нөхөр нь мэт хажуу дэргэдийн сэтгэлээр хийсвэрлэл дунд нь дүрсэлсэн байх юм. Нөгөө талаас сарны хөдөлгөөн, хэлбэр аранишин, өнгө зүсмийг нь олон талаас нь сэтгэлийн орон зайдаа баяжуулан гоо тансгаар дүрсэлжээ. Сар нэг бол бүтэн тэргэл, нэг бол хавирган, нэг бол тал байдаг биш юм. Бавуудоржийнхоор сар бол тухайн хүний сэтгэлийн мэлмийд яаж бууж байгаагаар л хэлбэр дүрсийг тодруулах боломжтойг хэлээд байна”* (Мөнхтөр, 2012:115). Тодруулбал:

“Сарны хөлд шаргал өвсний шүүдэр сүүдэхүй

Салхины мэдрэмж алганы хээнд сарнина...” гэх буюу:

“Мөнх бусад догдлон зогсоход минь

Мөнгөн сар араас татнам” гэх мэтчилэн шүлэглэсэн буй. Эдгээрээс “Сарны туулайн хүйтэн чихнээс” гэх шүлэг нь нэлээд өвөрмөц сэтгэлгээтэй шүлэг байна. *“Сарыг бэлгэдэхдээ нохой, туулай, багваахай, чоно, удган эрвээхэй, шар шувуу, муур, хавч, эмгэн хумс, далайн гахай, мэлхий, буга, луу, ягуур, арслан заан гэх зэрэг амьтантай холбож тайлбарладаг. Эдгээрээс хамгийн түгээмэл, олон улс орны аман зохиолоос орчин үеийн уран зохиолын төрөл, зүйл урсгал чиглэлд дүрслэгддэг нь туулай юм. Сарны туулайг Ази, Африк, Хойд америкийн улс орнуудын аман зохиолоос, Энэтхэгийн “Панчатантра буюу Таван сургамж”-аас тодорхой харж болно”* (Пүрэв-Очир, 2014: 239-240).

“Сарны туулайн хүйтэн чихнээс

Санаандгүй би атгаж үзсэн юм

Яруу найраг түүнд хүргэж өгснөөс хойш

Ялдам гэдэг үгийг олон хэрэглэхээ больсон юм”. Энэ шүлгийг судлаач А.Мөнх-Оргил онцгойлон тайлбарлаад *“Эдгээр мөрөөс нэлээд олон зүйлийг харж болохоор байна. Уянгын баатраас амьдралыг, ертөнцийг таньсан эгээрлийг харж болно”* гэжээ. *“Үүнийгээ саран дээрх туулайгаар дүрсэлсэн нь сэтгэлгээний хэв, гоо сайхны ухамсрын үүднээс дорно дахины ертөнцийн тухайт үзлийг илтгэж харин тэр нь хүйтэн чихтэй байгаа нь зохиолчийн зөвхөн бодгалийн дотоод сэтгэлгээний танилт, өвөрмөц баяжуулалт, уран сайхны нээлттэй холбогдох ертөнцийн сэрэл бүхий уран сэтгэмж мөн. Сарны туулайн чихнээс атгах гэдэг үгэнд уламжлалт сэтгэлгээг хөгжүүлэхдээ төлөөлөл ёгтлол үүсгэсэн нь дорнын уран сайхны сэтгэлгээнд ч, өрнийн урлагийн түүхэнд ч тохиолдож, яригдаж, маргаан мэтгэлцээн, онол бодролыг хандуулж байсан дүрслэл түүний цаадах сэтгэлгээний гүн аяс, ухамсарт амьдралын танин мэдэхүй нь ухамсаргүй бодомжид шингэн илэрч байгаа нь энэ юм. Гэхдээ уянгын баатрын хувьд түүнд хүрэх арга зам нь өөр юу ч биш яруу найраг байжээ. Яруу найраг уянгын баатарт саран дээр туулай байдаг, тэр нь хүйтэн чихтэй, бүр түүнийг нь атгахад тусалж байгаа нь бусад хүмүүсийн хэлдэгчлэн амьдрал, ертөнц байгаа нь өөр хаана ч хэзээ ч давтагдахааргүй яруу найргийн сэтгэлгээ, яруу найрагчийн мэдрэмж гэлтэй”* (ЯУТ, 2009: 172) хэмээн тайлсан байна. Энэ мэтээр Ц.Бавуудорж нь сарыг хүний сэтгэлийн нүдэнд хүртэж болох тэр л өнгөнүүдийг уран сайхны хэлээр тодорхойлж, сарны араншныг хүнчлэн, сарны мөн чанарыг тодруулсан олон дүрслэлийг бүтээжээ.

4.4. Ц.Бавуудоржийн яруу найраг дахь гэрэл гэгээний дүрслэлүүд

Монголчуудын үзэл ухамсарт “гэрэл” нь тэнгэрийн язгуур, ертөнцийн эх булагтай холбогддог. Тэнгэр шүтлэгийн нэгэн илрэл нь нар, сар, од, галаа дээдлэх, тэднийг ертөнцийн гэрэл гэгээний эх булаг гэж үзэх ойлголт юм. Гэрэл нь амьдрал, тэнгэрийн ивээл, оршихуйн ариун чанарыг илэрхийлдэг бэлгэдэлт дүр юм. “Монголын нууц товчоо”-ны 21-р зүйлд: *“Шөнө бүр цэгээн шар хүмүүн гэрийн өрх, тогтын гэгээгээр орж хэвэл минь билиж, гэгээн инү хэвэлд минь шингэх бүлгээ. Гараруун, наран сарны хилээр шар нохой мэт шарвалзан гарах бүлгээ. Дэлэмэ яахан өгүүлэх, та (та нар). Түүгээр ухваас, тэмдэг инү тэнгэрийн хөвүүд буюу зэ...”* (2011:13) хэмээн дүрсэлсэн байдаг. Энэхүү эшлэлд “цэгээн шар хүмүүн” гэх дүрээр тэнгэр язгуур, гэрлийн гэгээний уг сурвалжийг хүний оршихуйтай холбон дүрсэлсэн бол “шар нохой”-г тэнгэрийн хил дамнан шарвалзан гарах дүрээр өгүүлсэн нь хүнийг тэнгэрийн уг язгуурт хамааруулсан үзлийг нотлон харуулдаг.

Энэ мэтээр монгол утга соёлд “гэрэл” нь зөвхөн байгалийн нэгэн үзэгдэл бус, харин тэнгэрийн хөвгүүдийн уг гарвал, тэнгэрийн ивээл хийгээд оршихуйн ариун чанарын илэрхийлэл болсон бэлгэдэлт дүр, дүрслэл болдог.

Ц.Бавуудоржийн яруу найрагт ч дээр дурдсан “гэрэл гэгээ” илэрхийлсэн үгс, гэрлийг шүтэх үзэл давтамж үүсгэн түүний дор уянгын сайхан мөртүүд бий болж байдаг. Тодруулбал, *“Сормуус тэмтрэх сарны гэрэлд цас будрах нь тогтуун”*, *“Цармын гэрэлт цэцэгсийг мөндрийн зурвас дайрлаа”* гэх мэтчилэн юмсын гэрэлтэй чанарыг дуулсан нь бий. Тодруулбал, “Намрын өвсөн дунд” шүлэгт:

*“Гэрлээс гэрэл эхэлдгийг энэ хөх өвс надад хэлсэн
Гэрэлт оршихуй тэндээс эхэлдгийг бас хэлж өгсөн
Гэрлээс сүүдэр эхэлдгийг ч хэлж өгсөн
Гэгээн орчил хамт эхэлдгийг шивнэж хэлсэн
Харанхуйд гэрэл уйдашгүй гоо үзэсгэлэнтэй болдгийг шивнэсэн
Сөгдөшгүй хүчирхэг, ариун харагддагийг шивнэсэн
Биширмээр зөөлөн, тунгалаг бай гэж шивнэсэн*

Бие, сэтгэл чинь аяндаа гэрэл болно гэж шивнэсэн” хэмээн шүлэглэсэн буй. Энд өгүүлэн буй эхний мөр нь орчлонгийн бүхий л юмс өөрийн уг сурвалжаа гэрлээс, анхны туяанаас олсон хэмээх домог үлгэртэй холбогдох бөгөөд өвс хүртэл гэрлийн эх сурвалжийн тухай “хэлж өгнө” гэдэг нь байгаль ертөнц өөрөө гэрэлтэй ярилцагч, гэрлийн мэдлэгийн зуучлагч гэсэн санааг илэрхийлжээ. Түүнчлэн “Агай” найраглалдаа:

*“...Урт хар үсэндээ
Ганга агийн үнэртэй
Уран гол биендээ
Нар сарны гэрэлтэй...”
...Эрх хонгор харцандаа
Эддэж эвдрэхийн аргагүй
Сүүн цагаан гэрэлтэй...”*

*...Хүйтэн жавраар хайрч байвч
Агай чамайгаа дэргэдээ гэрэлтүүлнэ...”* гэхчлэн бичжээ. Мөн “Тэнгэрийн бүсгүй” хэмээх дууныхаа шүлэгт:

*“Гэр дүүрэн гэгээ татуулсан
Гэргий зандан амраг чи минь дээ
Гишгэсэн газартаа цэцэг ургуулсан
Гэээгтэй зандан тэнгэрийн бүсгүй еэ
Замиланг гийтэл мишээл цацруулсан
Завилсан зандан амраг чи минь дээ
Энгэр цээжиндээ хүүгээ эрхлүүлсэн
Ижий зандан тэнгэрийн бүсгүй еэ
Бөртэ сарыг дуултал уяраасан
Бүүвэй зандан хонгор чи минь дээ
Эсгэсэн торгондоо уянга дуслуулсан*

Ивээл зандан тэнгэрийн бүсгүй еэ гэж шүлэглээд

...Нар саранд сөгдөж гуйсан юм

Нандин учрал байлгүй дээ

Аргагүй ээ..." хэмээн шүлэглэсэн буй. "Энэ шүлгийн эхний бадгийн 1, 3-р мөрүүд "Гэр дүүрэн гэгээ татуулсан...Гишгэсэн газартаа цэцэг ургуулсан...", гэдэг болон 2-р бадгийн эхний мөр болох "Замиланг гийтэл мишээл цацруулсан..." гэдэг мөрүүд бол туульсын шууд уламжлалтай дүр, дүрслэл мөн болно" (Батсуурь, 2012). Дээрх шүлгүүдэд буй давтамжит үгсийг бид хувьдаа санамсаргүй тохиолдол, санаатайгаар тохиолдуулсан зүйл гэж бодохгүй зүгээр л ийн тохиочихсон "өгөгдөл" хэмээн ойлгож байна. Өөрөөр хэлбэл, ухамсаргүйгээр (инстинкт) үндэснийхээ соёлын бүтэц, ойлголтод хамаарах зүйлсийг сэдэж, сэтгэж, бичиж бүтээж байна гэж хэлж болно. Учир нь, монголчуудын гоо сайхны үзэлд онцгой сонирхол татах давтамжтай зүйл байдгийн нэг нь яах аргагүй гэрлийн үзэгдэлд хандах үзэл, шүтлэг юм. Монгол ардын баатарлаг туульд: "...Эмэгтэй хүний гоо сайхныг гэгээн цагаан гэрлээр төлөөлүүлэн дүрслэх ба Наран, Саран эрхсээр бэлгэдэх, эрэгтэй хүний сайхныг гэрлийн улаан өнгө гал цогтой холбон үзэх үзэл нь нэн тодорхой, давтамж өндөр байдаг" (Нандинбилиг, 2006:117). Тухайлбал, монгол туульсын зохиолд эмэгтэй хүний гоо үзэсгэлэнг

"Гэр нэвт туяатай

Гишүү улаан хацартай

Туурга нэвт туяатай

Тунгалаг улаан хацартай" хэмээн дүрсэлдэг бол орчин үеийн яруу найрагт ч эмэгтэй хүнийг гэрэл гэгээтэй зүйрлэн дуулсан нь олон бий.

Буддын шашны "гэгээрэл" хэмээх ойлголт ч шууд утгаарай гэрэлтэй холбоотой билээ. Бурхан багшийн эргэн тойронд "гэрлийн туяа" дүрслэгддэг нь үнэн, нигүүлсэл, амар тайвныг илтгэсэн бэлгэдэл болдог аж. Ц.Бавуудоржийн яруу найрагт ч энэ гэгээрэлтэй холбогдсон гэрлийн дүрслэлүүд бий. Тодруулбал, "Харсаар байтал" шүлэгт:

"Харсаар байтал чиний дэргэдээс

Хачин тунгалаг хүн

Босоод явчихлаа

Хаа хүрэхийг нь би мэдэхгүй ч

Харин хэзээ ч эргэж ирэхгүй нь

Халуун зөнгөөрөө мэдэрч байна" гэж эхэлдэг бөгөөд үүнийг номын өмнөтгөл үгэнд "хүний амьсгун, цог хийморийн үнэтэй бүхэн үгүй болсноор бие нь үлдэх агшныг хүртэл өгүүлсэн нь найрагчийн үхлийн мөн чанарыг мэдрэх хийсвэр талын илэрхийлэл" хэмээн агуулгын талаас нь тайлбарласан байдаг. Үүнийг судлаач А.Мөнх-Оргил арай өөрөөр тайлбарласан байна. Тодруулбал,

"Танхилхан чамайг минь гэрэлтэй болгодог

Тарни нь тэр байсныг

Сая л цочин анзаарлаа" гэсэн мөрүүдээс хүний сэтгэлийн мөн чанар, буртаггүй гэгээн чанарыг юу эвддэг тухай өгүүлснийг харж болно. Тэрхүү ариун сэвгүй чанарыг хажууд нь тунгалаг хүн байдаг, биед нь гэрлэн бурхан оршдог, нүдэнд нь болор загас байдаг, алганд нь алтлаг хээ байдаг зэргээр төлөөлөн дүрслээд харин үүнийг хорвоогийн салхи арчдагаар бичсэн нь хорвоо ертөнц, амьдрал гэгч хүнийг тэр алтлаг, гэрлэн, тунгалаг, болор чанараас нь өөрийн эрхгүй салган оддог тухай гашуун үнэнийг харуулсан байна".

"Үхэл ирэхэд би тув тунгалаг болно

Үлдэж энэ орчлон манан дундаа умбана

Үр минь, хүү минь харин тод тунгалаг төрнө

Үйлийн эрхээр тэр минь хатан болроо алдана

Хоёр тунгалгийн хоорондох хорвоо гэдэг юм даа

Хоёр тунгалгаас бусдад нь

Хонгор минь битгий итгээрэй" гэсэн өөр нэгэн шүлэгт гүнзгийрэн төгөлдөржсөнийг бас харж болно. Уянгын баатар өөрөө мананд умбасан орчлонг орхиж үхэхэд л тунгалаг болно, харин түүнтэй зөрж төрөх хүү тод тунгалаг төрж байна. Үйлийн эрхээр буюу орчлонгийн жамаар хүү нь амьдралд, цаг хугацааны хуульд захирагдах нь түүнийг хатан болроо алдахад

хүргэж байна. Энэ бол хүүгээс үл хамаарах ер нь хэнээс үл хамаарах хорвоогийн жам зарлиг юм. Энэхүү энгийн үнэнийг цааш гүнзгийрүүлэн ерөөс үхэх төрөх л юм гэсэн дотоод сэтгэлийн их ухаарал, амьдралын мөн чанарыг таньсан гэгээрлийг олж үзэж болно (ЯУТ. 2009: 174-175).

5. Дүгнэлт

1. Ц.Бавуудоржийн яруу найрагт монгол үндэстний сэтгэлгээ, соёлын бүтэц дэх эх дүр, уг гарвал ухамсаргүйгээр уламжлагдсан байна. Тодруулбал, түүний яруу найрагт монголчуудын тэнгэрийг шүтэх үзэл, гэрлийг шүтэх үзэл, сарны бэлгэдэлт дүр зэргийн дүрслэл өгүүлэмж “архетип” байдлаар уламжлагджээ.

2. Ц.Бавуудоржийн шүлэг найргийн онцлог нь хүний амьдралыг дан ганц оршихуйн хувийн хүрэнээс бус, харин сав шимийн мандалтай харилцан уялдаатайгаар дүрслэхэд оршдог.

3. Аливаа уран бүтээлчийн бүтээсэн уран чадварын туршлагыг хожмын үеийн туурвигч нарт тодорхой уламжлал болж буй шалгуураар хэмжих зүй тогтол бий. Өөрөөр хэлбэл, энэ асуудал нь уран зохиолын уламжлал шинэчлэлийн харилцаа холбооны тухай ойлголт бөгөөд хожмын үеийн бүтээл туурвилд өөрийн нөлөө туршлагыг хэдий чинээ шингээн өвлүүлж чадна тэрхүү бүтээл гарцаагүй шилдэг бүтээл мөн хэмээгдэх жамтай. Энэ ч утгаараа Ц.Бавуудорж нь аман зохиол болоод бичгийн нэрт зохиолч төлөөлөгчдийн уран бүтээл, туурвил зүйн сэтгэлгээний уламжлалыг өвлөн залгамжлахын зэрэгцээ уран сайхны сэтгэлгээний шинэчлэл хийж, улмаар уянга яруу найргийг хөгжүүлэн төлөвшүүлсэн зохиолч гэж үзэж болно.

Ном зүй

- Бавуудорж, Ц.** (2016). *Нар сар сар нар*. Улаанбаатар: [Bavuudorj, Ts. *Nar sar sar nar* [Sun Moon, Moon Sun]. Ulaanbaatar: 2016]
- Бавуудорж, Ц.** (2022). *Дорно зүгт өвс болно*. Улаанбаатар: [Bavuudorj, Ts. *Dorno zügt üvs bolno* [I Will Become Grass in the East]. Ulaanbaatar: 2022]
- Бавуудорж, Ц.** (2022). *Уянгын шүлгүүд*. Улаанбаатар: [Bavuudorj, Ts. *Uyangyn Shülgüüd*. [Lyrical Poems]. Ulaanbaatar: 2022]
- Байгалсайхан, С.** (1995). *Уран зохиол шинжлэлийн удиртгал*. Улаанбаатар: УХГ. 151 х. [Baigalsaikhan, S. *Uranzokhiol shinjleliin udirtdgal* [Introduction to Literary Studies]. Ulaanbaatar: 1995.]
- Батсуурь, Г.** (2012). *Амар амгалангийн дайд*. Улаанбаатар: <https://bavuudorj-poet.blogspot.com/2015/10/2012>. [Batsuuri, G. *Amar amgalangiin daid* [At the Boundary of Peace and Tranquility]. Ulaanbaatar: 2012]
- Батсуурь, Г.** (2018). *Ерөөлчид ба шизофренчууд*. УЗСШ. Улаанбаатар: Жиком пресс. 214 х. [Batsuuri, G. *Yörüülchid ba Schizophrenicüüd* [Prophets and Schizophrenics]. Ulaanbaatar: 2018]
- Бямбаниям У.** (2012). *Бүтэц, дүр, архетип*. “Эх хэл” сэтгүүл. Улаанбаатар: 2012. <https://www.tumblr.com/byambanyam-blog>. [Byambanyam, U. *Bütets, dür, archetype* [Structure, character, Archetype]. Ulaanbaatar: 2012]
- Дулам, С.** (1989). *Монгол домог зүйн дүр*. Улаанбаатар: УХГ. 192 х. [Dulam, S. *Mongol domog züin dür* [Characters in Mongolian Mythology]. Ulaanbatar: 1989]
- “МНТ”.** (2011). *Монголын нууц товчоо*. Шинэ хөрвүүлэг, тайлбар сэлт үйлдсэн Ш.Чоймаа. Улаанбаатар: “Мөнхийн үсэг” ХХК. [Mongolyn nuuts tobchoon [The Secret History of the Mongols]. Ulaanbaatar: 2001]
- Мөнхтөр, Л.** (2012). *Жаргалын найман морь*. V боть. Тоонот принтинг. Уб., 212 х. [Munkhtur, L. *Jargalyn naitan mori* [The Eight Horses of Joy]. Ulaanbaatar: 2012]
- Нямдорж, Ү.** (1994). *Соёлын философи, Монголын соёл*. Улаанбаатар: 41 х. [Njamdorzh, Ü. *Soyolyn philosophy, Mongolyn Soyol* [Philosophy of Culture, Mongolian Culture]. Ulaanbaatar: 1994]
- Пүрэв-Очир, Б.** (2014). *Дашдоржийн Нацагдорж болон түүний*. Улаанбаатар: “Мөнхийн үсэг” ХХК. [Purev-Ochir, B. *Dashdorjiin Natsagdorj болон түүний* [Dashdorjyn Natsagdorj and His...]. Ulaanbaatar: 2014]
- УЗШ.** (2021). *Утга зохиол шинжлэл*. МУБИС-Утга зохиолын тэнхимийн багш нар. Ред. С.Энхбаяр. Улаанбаатар: 768 х. [Uta zokhiol shinjlel [Literary Analysis]. Ulaanbaatar: 2021]
- Ууганбаатар Ж.** 2018. *Уламжлал шинэчлэл ба “Дарлан банди”-аас “Тунгалаг тамир”*. “Хэл зохиол судлал”-2018. Tom. XI (43). Fasc.21. 245-254 дүгээр тал. Улаанбаатар: [Uuganbaatar, J. *Ulamjlal shinechilel ba “Darlan Bandi”-aas “Tungalag tamir”* [Tradition and Innovation: From Darhan Bandi to Tungalag Tamir]. Ulaanbaatar: 2018]

- Цэвээндорж, Д.** (2009). *Эрин цагийн шүүмж*. Редактор Д.Цэдэв. “Greenmirror” ХХК. 320 х. [Tseveendorj, D. *Eren tsagiin shuuj* [Criticism of the Era]. Ulaanbaatar: “Greenmirror” press. 2009]
- Цэдэв, Д.**(2002). “*Монголын нууц товчоо*”-ны бэлгэдэл зүй. Улаанбаатар: Интерпресс. 332 х. [Tsedev, D. “*Mongolyn nuuts tobchoo*”-ny belgedel züi [Symbolism in The Secret History of the Mongols]. Ulaanbaatar: 2002]
- Энхтүшиг, Л.** (2019). *Психоанализ*. Улаанбаатар: 192 х. [Enkhtüshig, L. [Psychoanalysis]. Ulaanbaatar: 2019]
- Юнг, К.Г.** (2011). *Бэлгэдэлт амьдрал*. Орч: Энхбаатар. Улаанбаатар: 203 х. [C.G.Jung, *Symbolic Life*. Translator: Enkhbaatar. Ulaanbaatar: 2011]
- ЯУТ-П.** (2009). *Яруу утгын тайлал-II*. Шүүмжийн эмхэтгэл. Монголын үндэсний чөлөөт зохиолчдын холбоо. Улаанбаатар: 316 х. [*Yaruu utgiin tailal* [Interpretation of Poetic Meaning – II]. A Collection of Criticism. Ulaanbaatar: 2009]